

**МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, НИЙГМИЙН ДААТГАЛЫН
САНГИЙН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
САНГИЙН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ ХУУЛИЙН
ШААРДЛАГА ХАНГАСАН ЭСЭХЭД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

2022 оны 10 дугаар
сарын 06-ны өдөр

Улаанбаатар
хот

Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 22.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2023 оны төсвийн төсөлд Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын 2022 оны 347 дугаар захирамжаар батлагдсан “Төсвийн төсөлд дүн шинжилгээ хийх аргачлал”-ын дагуу Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсээс дүн шинжилгээ хийж, дараах танилцуулгыг бэлтгэн Та бүхэнд хүргүүлж байна.

**Нэг.Төсвийн төсөл нь Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх
хэсгийн 7-д заасны дагуу улсын хөгжлийн болон үндэсний аюулгүй
байдлын бодлогод нийцсэн эсэх:**

1.1.“Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангасан байдал:

Хүснэгт 1.

Үзүүлэлт	Тусгагдсан байдал
Хүнсний хангамж, аюулгүй байдлын хөтөлбөрт тусгасан 2023 онд хийгдэх ажлын зорилт, холбогдох шалгуур тус бүрээр төлөвлөсөн эсэх	Энэхүү хөтөлбөр нь 5 зорилтын хүрээнд нийт 114 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, уг хөтөлбөрийн хүрээнд 2022-2026 онуудад нийт 1,749.9 тэрбум төгрөг, үүний дотор 2023 онд 521.0 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөсөн. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 2023 онд нийт 521.0 тэрбум төгрөг шаардлагатайгаас улсын төсвөөс 252.9 тэрбум, гадаадын зээл тусламжаас 190.2 тэрбум төгрөг байхаар хөтөлбөрт тусгасан. Засгийн газраас төсвийн төслийг өргөн мэдүүлсэн танилцуулгад хүнсний хангамж, аюулгүй байдлын хөтөлбөрт 228.2 тэрбум төгрөгийн урсгал зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр тусгасан байна.

Эх сурвалж:Монгол Улсын 2023 оны төсвийн төслийн тооцоолол

1.2.Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн эсэх:

Монгол Улсын Их Хурал 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 26 дугаар тогтоолоор “Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичиг”-ийг баталсан бөгөөд уг баримт бичигт 6 зорилт дэвшүүлсэн. Өрийн удирдлагын стратегийн бодлогын баримт бичгийн 2, 4, 5 дугаар зорилтын хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр төсвийн төсөлд тусгасан байна:

Хүснэгт 2.

Зорилт	Төсвийн төсөлд тусгасан арга хэмжээ
Зорилт 2: Засгийн газрын үнэт цаасны төлбөрүүдийг эдийн засаг, төсөвт дарамт учруулахгүйгээр төлж, дахин санхүүжилтийн эрсдэлийг бууруулах	Арга хэмжээ: Төсвийн төслийн хамт Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг өргөн мэдүүлсэн. Үндэслэл: 2023 оны 05 дугаар сард эргэн төлөгдөх хуваарьтай “Гэрэгэ” бондын төлбөр болох 533.1 сая ам.доллар, 2024 оны 09 дүгээр сард төлөх “Хуралдай”

	бондын төлбөр болох 600.0 сая ам.доллар, нийт 1,133.1 сая ам.долларын өрийн зохицуулалтын арга хэмжээ авахаар төлөвлөсөн. Гадаад зээл, үнэт цаас гаргахад хүү нэмэгдэх, гадаад валютын ханш чангарах өндөр эрсдэлтэй тул дотоод зах зээлээс үнэт цаас гаргахаар тооцоолжээ.
Зорилт 4: Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийн хөгжлийг дэмжих, үнэт цаасны арилжаа тогтмолжуулах	Арга хэмжээ: Төсвийн төслийн хамт Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл өргөн мэдүүлсэн. Үндэслэл: Зорилт 2-т тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхдээ дотоодын зах зээл дээр Засгийн газрын үнэт цаасыг гаргахаар төлөвлөсөн бөгөөд төсвийн алдагдлыг санхүүжүүлэх, Засгийн газрын өрийн оновчтой багцын бүтцийг бий болгох зорилгоор үнэт цаасыг арилжаалахаар тооцжээ.
Зорилт 5: Улсын стратегийн томоохон төслүүдэд Засгийн газрын өрийн баталгаа гаргах, хувийн хэвшлийн компаниудад дэмжлэг үзүүлэх байдлаар Монгол Улсын эдийн засгийн урт хугацааны зорилтыг хангаж, болзошгүй төлбөрийн эрсдэлийг хязгаарлах	Арга хэмжээ: Төсвийн төслийн хамт Засгийн газрын баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл өргөн мэдүүлсэн. Үндэслэл: 2023 онд 24.3 тэрбум иенийн дүнтэй “Самурай” бонд, 500.0 сая ам.долларын дүнтэй “Сэргэн мандалт” бондын төлбөр төлөгдөхөөр байна. Дээрх төлбөрүүдийг Хөгжлийн банкны зүгээс өөрийн хөрөнгөөр төлж барагдуулах эсвэл дахин санхүүжүүлэх боломжгүй тохиолдолд Засгийн газрын зүгээс өрийн баталгаа гаргах замаар зээлийн эргэн төлөлтийн эрсдэлээс сэргийлэхээр тооцоолжээ.

Эх сурвалж: Сангийн яам

1.3.Төсвийн төсөл нь Үндэсний аюулгүй байдлын бодлогод чиглэгдсэн эсэх:

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29.1 дэх хэсэгт “Хуулийн төслийн агуулга дараах нийтлэг шаардлагыг хангасан байна.” гэж, 29.1.1 дэх заалтад “Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;” гэж, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22.1.1 дэх заалтад “төсвийн төсөл нь Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасны дагуу улсын хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцсэн байх;” гэж, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3.4 дэх хэсэгт “Үндэсний аюулгүй байдал нь дараах 10 хэсэгтэй байна.” гэж тус тус заасан.

“Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралтын Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсгийг хангасан эсэхийг хянах, үнэлэх шалгуур үзүүлэлт, арга зам тодорхой хуульчлагдаагүй байх тул өргөн мэдүүлсэн төсвийн төсөл нь төсөв, санхүүгийн салбарын аюулгүй байдал хэсэгт заасан шалгуур үзүүлэлтүүдэд чиглэгдсэн эсэхэд дараах байдлаар шинжилгээ хийж үзлээ.

Хүснэгт 3.

Д/д	Арга зам	Чиглэгдсэн эсэх
1	Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, урт хугацааны өсөлт хөгжлийг дэмжих эрүүл, тогтвортой, сахилга баттай санхүүгийн салбарыг төлөвшүүлнэ	2023 оны төсвийн төсөлд “Шинэ сэргэлт”-ийн бодлогыг хэрэгжүүлэх, санхүүжилтийн эх үүсвэрийн төрөлжилтийг нэмэгдүүлэх зорилтыг хэрэгжүүлэхээр тусгажээ. Тухайлбал хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, үнэт цаасны зах зээл, мэдээллийн технологийн салбарыг хөгжүүлэх, бизнесийн орчныг дэмжих татварын бодлогын хүрээнд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлсэн. Энэ нь хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, санхүүгийн салбарт банкны зах зээл давамгайлсан байдлыг засахад эерэг нөлөө үзүүлэхээр байна.

		Түүнчлэн санхүүгийн салбарын тогтвортой байдлыг илтгэгч гол үзүүлэлт болсон нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын ДНБ-д эзлэх хэмжээг -2.8 хувьд хүргэхээр төлөвлөсөн байгаа нь сахилга баттай санхүүгийн салбарыг төлөвшүүлэхэд дэмжлэг болно гэж үзсэн байна.
2	Засгийн газрын авах зээл нь бодит эдийн засгийн салбарт чиглэгдэх бөгөөд эдийн засгийн аюулгүй байдлыг хангасан, зохистой харьцаанд байна	2023 онд 2.6 их наяд төгрөгийн урт хугацаат Засгийн газрын бонд гаргаж, 1.6 их наяд төгрөгийн дотоод, гадаад бондын үндсэн төлбөр төлөх, 1.22 их наяд төгрөгийн гадаад зээл, 350 тэрбум төгрөгийн хөтөлбөрийн зээл авч, 1.16 их наяд төгрөгийн төслийн зээлийн үндсэн төлбөр төлөхөөр тус тус төлөвлөжээ. Засгийн газар нийт 4.17 их наяд төгрөгийн зээл авч 2.7 их наяд төгрөгийн зээлийн үндсэн төлбөрийг төлж, 1.41 их наяд төгрөгийг бодитой ашиглахаар төлөвлөжээ. Төсвийн зардлыг санхүүжүүлэхэд Засгийн газрын авах зээлийн 33.8 хувийг ашиглахаар төлөвлөсөн байна.
3	Гадаад валют, алтны нөөцийг үндэсний импортын нэг жилийн хэрэгцээг хангах хэмжээнээс багагүй түвшинд байлгана. Цаашид нөөцийг нэмэгдүүлэх, удирдлагыг боловсронгуй болгох урт хугацааны арга хэмжээг хэрэгжүүлнэ	Гадаад валютын албан нөөцийн импортын хэрэгцээг хангах хүрэлцээ 2022 оны эхний хагас жилийн байдлаар 4.2 сар байна. 2023 онд Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төсвийн төсөлд “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх, эдийн засгийг төрөлжүүлэх, бүхий л салбарт боловсруулалтын түвшнийг ахиулах, боомт, тээвэр логистикийн хүчин чадлыг дээшлүүлэх бодлогын зорилтуудыг дэвшүүлсэн байна.
4	Мөнгөний бодлогын үр дүнг дээшлүүлж, үндэсний мөнгөн тэмдэгтийн худалдан авах, хөрвөх чадварыг сайжруулж, тогтворжуулна. Дотоодын гүйлгээ, төлбөр, тооцоонд зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтийг хэрэглэж, үндэсний мөнгөн тэмдэгтийн дотоодын зах зээлд эзлэх хувь, хэмжээг зохистой хэмжээнд байлгана	Банкны салбарын зээлийн долларжилт буурсан ч эх үүсвэрийн долларжилт нэмэгдэх хандлагатай байгаа нь банкуудын баланс дахь валютын тэнцвэрт бус байдлыг нэмэгдүүлж, банк, санхүүгийн салбарт эрсдэл хуримтлагдах нөхцөлийг бүрдүүлж байна ¹ . Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөлд Монголбанкнаас “Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцыг 2023 онд нэг оронтой тоонд, дунд хугацаанд +/-2 нэгж хувийн интервалд 6 хувийн орчимд тогтворжуулахад чиглэсэн мөнгөний бодлогыг зах зээлийн зарчимд тулгуурлан хэрэгжүүлнэ.” гэсэн зорилт, арга хэмжээг тусгасан байна. Инфляц зорилтот түвшинд хүргэх замаар үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшийг тогтворжуулахаар зорьжээ.
5	Банк дундын эрсдэлийн сан байгуулж, санхүүгийн байгууллагын буруугаас үүдсэн аливаа хохирлыг төр хариуцах зарчмаас татгалзана	“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэл” Улсын Их Хурлаар батлагдаагүй, хэлэлцүүлгийн шатанд байгаа бөгөөд төсөлд банкны салбарын тогтвортой байдлын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлсэн нь төсвийн бодлогыг хэрэгжүүлэх санхүүгийн орчныг бүрдүүлэхэд дэмжлэг болно гэж үзжээ. Үүнд: <ul style="list-style-type: none"> ◆ Банкны салбарын хяналт шалгалт, зохицуулалтын арга хэрэгсэл, үнэлгээний аргачлалыг олон улсын жишиг, зарчимд нийцүүлэх бодлого, арга хэмжээг үргэлжлүүлнэ; ◆ Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг нэвтрүүлэх хүрээнд банкны салбарын макро стресс тестийн аргачлалыг боловсронгуй болгож, системийн болон тухайлсан банкны эрсдэлийн үнэлгээг нэвтрүүлнэ; ◆ Банкны салбарын зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон шүүхийн шийдвэрийн үр дүнтэй байдлыг сайжруулах, харилцагчийн хууль ёсны эрхийг хамгаалах чиглэлээр хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлыг үргэлжлүүлнэ.

¹ Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл

6	Гадаад, дотоод томоохон төлбөр, тооцоо, зээл, аккредитивийн хөдөлгөөнд хяналт тавих, эдийн засаг, санхүүгийн салбарын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, шалгаж шийдвэрлэх тогтолцоог хөгжүүлнэ	<p>“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэл” Улсын Их Хурлаар батлагдаагүй, хэлэлцүүлгийн шатанд байгаа бөгөөд Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөлд санхүүгийн захын дэд бүтэц, түүний институцийг бэхжүүлэх хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлсэн нь санхүү, төсвийн эрүүл харилцааг бий болгох нөхцөлийг бүрдүүлэхээр байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Үндэсний төлбөрийн системийн эрх зүйн зохицуулалтыг сайжруулах зорилтын хүрээнд Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийг дагаж мөрдөхөд тулгарч байгаа хүндрэл, холбогдох бусад хуультай үүсэж байгаа давхардал, хийдэл байгаа эсэхийг тодорхойлж тус хуулийг шинэчлэн найруулгын төслийг боловсруулахаар; • Төлбөрийн хэрэгслийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжиж ажиллах зорилтынхоо хүрээнд Төлбөр тооцооны газар нь Азийн хөгжлийн банкны "Төлбөрийн системийн шинэчлэл төсөл"-ийн санхүүжилтээр 2022 онд Төв банкны Үндсэн бүртгэлийн систем, Их өгөгдөл (Big data), Token баталгаажуулах систем гэсэн дэд системийг шинээр нэвтрүүлэхээр тус тус тусгажээ.
---	--	---

Хоёр.Төсвийн тухай болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шалгуурыг хангасан эсэх:

Төсвийн тухай хуулийн 4.1.4 дэх заалтад “төсвийн төсөл” гэж дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд үндэслэн, хуульд заасан шаардлагын дагуу төсвийн шатлал бүрээр төсвийн ангилал ашиглан Засгийн газраас Улсын Их Хуралд, түүнчлэн бүх шатны Засаг даргаас тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн төсвийн саналыг;” гэж, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Төсөвт дараах шаардлагуудыг нэгэн зэрэг хангагдсан байна: гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр баталсан “Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 88 дугаар тогтоолын 6 дахь заалтад “Монгол Улсын тухайн жилийн төсвийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхдээ дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэх, хөгжлийн бодлогод нийцсэн, нотолгоо, үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтийг хэрэгжүүлэх” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлаас Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдөр баталж, батлагдсан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн төсвийн төслийг боловсруулах чиглэлийг Засгийн газарт өгсөн боловч, батлагдсан төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулахаар төсвийн төслийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна.

2.1.Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийн тухай хуульд нийцсэн байдал:

Нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг **18,921.9** тэрбум төгрөг буюу ДНБ-ий 34.7 хувь, нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээг **20,475.3** тэрбум төгрөг буюу ДНБ-ий 37.6 хувь байхаар тооцож, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл **1,553.4** тэрбум төгрөг буюу ДНБ-ий **2.8** хувьтай тэнцэх хэмжээний төсвийн алдагдалтай байхаар тусгасан байна.

Хүснэгт 4.

	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Төсвийн хүрээний мэдэгдэл			Төсвийн төсөөлөл	
		Бат /2022.05.27/	Төс /2022.09.29/	Өөрчлөлт	2024 он	2025 он
1	Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	5.0	5.0	0.0	5.1	6.1
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	8.0	8.0	0.0	6.0	6.0
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	17,312.2	18,921.9	1,609.7	20,797.4	21,859.9
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	32.7	34.7	2.0	36.3	34.5
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	19,219.1	20,475.3	1,256.2	22,401.7	23,128.8
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	36.3	37.6	1.3	39.1	36.5
5	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/	1,305.6	2,561.8	1,256.2	1,926.4	727.1
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	2.5	4.7	2.2	3.4	1.1
6	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-1906.8	-1553.4	353.4	-1604.4	-1269.0
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	-3.6	-2.8	0.8	-2.8	-2.0
7	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	4,484.4	5,347.3	862.9	5,850.4	6,040.3
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	8.5	9.8	1.3	10.2	9.5
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /тэрбум төгрөг/	34,428.4	35,434.5	1,006.1	34,379.2	38,068.7
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	65.0	65.0	0.0	60.0	60.0
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	604.8	1,999.0	1,394.2	2,115.6	2,135.3
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	1.1	3.7	2.6	3.7	3.4

Эх сурвалж: Батлагдсан төсвийн хүрээний мэдэгдэл², Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл³

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзүүлэлтүүдийг батлагдсан нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтүүдтэй харьцуулахад дараах үр дүн гарсан. Үүнд:

1. Монгол Улсын Их Хурлын 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр баталсан “Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 88 дугаар тогтоолоор төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн төсвийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг даалгасан боловч, төсвийн төслийн хамт дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг өргөн мэдүүлсэн. Өргөн мэдүүлсэн дүнг батлагдсан дүнтэй харьцуулахад нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 1,609.7 тэрбум төгрөгөөр, зарлагын хэмжээг 1,256.2 тэрбум

² - 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдөр баталсан “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай” хууль

³ Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, тэнцвэржүүлсэн тэнцлийг 353.4 тэрбум төгрөгөөр бууруулахаар тооцоолсон байна.

- Монгол Улсын Их Хурлаар 2022 оны 5 дугаар сарын 27-ны өдөр батлагдсан төсвийн хүрээний мэдэгдлийн нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээнд барьж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 1,609.7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж төсвийн төслийг өргөн мэдүүлсэн бол нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл өргөн мэдүүлсэн дүнгээс дахин буурах боломжтой байжээ.
- Төсвийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр тус сангийн 5 эх үүсвэрийн 1 эх үүсвэр болох “ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр”-өөс Тогтворжуулалтын санд хуваарилж, үлдэх хэсгийн 65.0 хувийг “Ирээдүйн өв сан”-д хуваарилах зохицуулалтыг өөрчилж, 2023 онд Ирээдүйн өв санд хуваарилах хувийг “0” байхаар тооцож, улсын төсөвт 1,563.6 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 2.8 хувьтай тэнцэх хэмжээний ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг нэмж тусгаснаар нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал тодорхой хэмжээгээр буурсан байна. Энэ хуулийн төслийг батлахгүй тохиолдолд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал 2.8 хувиар нэмэгдэж, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалтад заасан шаардлага хангагдахгүй болох эрсдэл эсхүл нэгдсэн төсвийн нийт зарлагыг мөн хэмжээгээр бууруулах шаардлага үүсэхээр байна.
- Төсвийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн “Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” УИХ-ын тогтоолын төсөл, “Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” УИХ-ын тогтоолын төсөл батлагдсанаар 1,633.1 сая ам.доллар, 24.3 сая иэнтэй дүйцэх хэмжээгээр Засгийн газрын өр нэмэгдэж, Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн өрийн үлдэгдэл 35,434.5 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 65.0 хувьд хүрч, дээд хязгаарт тулахаар байна.

2005-2023 онуудын төсвийн тэнцлийг судлан үзэхэд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 19 жилээс зөвхөн 5⁴ жилд ашигтай, 14 жилд нь байнга алдагдалтай батлагдаж байжээ. Өөрөөр хэлбэл жилд дунджаар 4.2⁵ хувийн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдалтай явж ирсэн байна.

График 1. Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого, зарлага, тэнцлийн үзүүлэлт (тэрбум төг)



Эх сурвалж: УСХ, СЯ

⁴ Төсөв ашигтай байсан жилүүдэд 2005-2007, 2010 болон 2018 онууд багтаж байна.

⁵ Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, зарлага болон тэнцлийн ДНБ-нд эзлэх хувийг авч үзэхэд 2005-2023 онд орлого 30.4 хувь, зарлага 34.6 хувь, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал дунджаар 4.2 хувьтай байна.

2.2.Батлагдсан төсвийн хязгаартай төсвийн төслийг харьцуулсан байдал:

Төсвийн тухай хуулийн 4.1.8-д “жилийн төсвийн хязгаар” гэж төсвийн тусгай шаардлага, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн төсөв боловсруулахад баримтлах орлогын доод хэмжээ, зарлагын дээд хэмжээг” гэж, 27.1.4-т “жилийн төсвийн хязгаарт үндэслэсэн байх” гэж, 29.3.1-д “дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл болон жилийн төсвийн хязгаарт багтаах;” гэж, мөн 31.1.3-д заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн төсөл жилийн төсвийн хязгаарт багтсан байх шаардлагыг хуульчилсан байдаг.

Төсвийн ерөнхийлөн захирагч нар нийт дүнгээрээ 32.9 их наяд төгрөгийн төсвийн төслийн саналыг боловсруулж, Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн нь батлагдсан төсвийн хязгаараас 20.5 их наяд төгрөгөөр буюу 165 хувиар давсан. Түүнчлэн Засгийн газраас өргөн мэдүүлсэн төсвийн төсөл нь өөрийн баталсан төсвийн хязгаараас 3.2 их наяд төгрөгөөр буюу 25.8 хувиар өндөр байгаа нь Засгийн газар төсвийн төслийг батлагдсан төсвийн хязгаараас давуулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна.

Хүснэгт 5.

/сая төгрөгөөр/

№	Төсвийн Ерөнхийлөн захирагчид	Төсвийн хязгаар (ЗГ-ын 258 дугаар тогтоол)	ТЕЗ-ын төсвийн санал (2022.08.15-нд СЯ, УИХ-д хүргүүлсэн)	Төсвийн төсөл (ЗГ-аас УИХ-д 2022.09.29-нд өргөн мэдүүлсэн)
1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга	19,678.9	31,055.8	26,578.8
2	Монгол Улсын Их Хурлын дарга	62,369.9	66,675.4	60,756.2
3	Монгол Улсын Үндсэн хуулийн цэц	2,912.2	3,911.7	3,367.5
4	Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч	9,059.6	11,164.3	11,164.1
5	Шүүхийн ерөнхий зөвлөл	76,302.8	150,854.6	90,643.1
6	Хүний эрхийн үндэсний комиссын дарга	2,739.9	4,560.2	4,515.2
7	Улсын ерөнхий прокурор	59,337.9	130,975.3	67,938.7
8	Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга	9,489.0	178,305.9	15,104.3
9	Монгол Улсын Ерөнхий аудитор	24,840.0	29,216.8	26,625.8
10	Авлигатай тэмцэх газрын дарга	33,222.1	35,461.0	33,129.6
11	Санхүүгийн зохицуулах хорооны дарга	7,451.3	10,695.2	8,067.6
12	Төрийн албаны зөвлөлийн дарга	2,311.6	3,602.1	3,539.0
13	Үндэсний статистикийн газрын дарга	16,077.1	26,126.0	19,206.9
14	Сонгуулийн ерөнхий хорооны дарга	7,103.8	55,794.8	4,296.7
15	Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс	15,322.3	21,721.7	15,402.0
16	Монгол Улсын Ерөнхий сайд	253,280.2	483,606.1	236,822.2
17	Монгол Улсын Шадар сайд	186,735.5	520,653.0	182,892.8
18	Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд	312,134.1	322,934.5	297,986.9
19	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	57,841.0	196,510.5	74,833.8
20	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд	126,444.1	333,473.4	114,656.5
21	Гадаад харилцааны сайд	114,002.1	263,691.2	154,825.2
22	Сангийн сайд	3,789,574.6	8,336,275.8	3,918,913.9
23	Хууль зүй, дотоод хэргийн сайд	651,474.9	2,894,500.0	777,387.4
24	Зам тээврийн хөгжлийн сайд	306,762.2	1,006,346.7	492,261.7

25	Батлан хамгаалахын сайд	265,856.3	711,273.6	310,511.7
26	Боловсрол, шинжлэх ухааны сайд	2,247,673.2	6,242,852.1	2,730,061.7
27	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын	40,961.4	91,168.1	40,151.4
28	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	356,118.9	1,061,847.4	525,089.9
29	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	1,754,715.7	3,394,834.4	2,757,275.7
30	Эрүүл мэндийн сайд	977,119.9	3,222,041.5	1,261,205.4
31	Эрчим хүчний сайд	143,226.2	735,071.0	171,430.5
32	Барилга хот байгуулалтын сайд	248,828.6	1,326,295.2	421,556.5
33	Соёлын сайд	186,955.1	919,492.8	263,155.9
34	Цахим хөгжил, харилцаа холбооны сайд	36,453.7	80,646.1	64,117.8
35	Шүүхийн сахилгын хороо	3,529.0	3,234.4	3,243.7
36	Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны дарга	-	-	79,443.5
37	Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга	-	-	2,636.4
38	Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга	-	-	339,743.2
Нийт		12,407,905.1	32,906,868.6	15,610,539.2

Эх сурвалж: СЯ

Дээрх харьцуулсан хүснэгтэд Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны дарга, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга нарын төсвийн мэдээлэл ороогүй болно.

Төсвийн ерөнхийлөн захирагчдаас 35 төсвийн ерөнхийлөн захирагч Засгийн газрын 258 дугаар тогтоолоор баталсан төсвийн хязгаараас 1 төсвийн ерөнхийлөн захирагчаас бусад 34 төсвийн ерөнхийлөн захирагч 0.3-1,473.3 тэрбум төгрөгөөр урсгал зардлыг, Монгол Улсын Ерөнхий аудитор, Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдаас бусад 32 төсвийн ерөнхийлөн захирагч 0.3-2,825.8 тэрбум төгрөгөөр хөрөнгийн зардлыг тус тус хэтрүүлж, төсвийн саналаа ирүүлсэн байна.

2.3.Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагыг хангасан эсэх:

Хүснэгт 6.

Д/д	Төсвийн тусгай шаардлагын үзүүлэлтүүд	Төсвийн тусгай шаардлага хангасан эсэх																
1	Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх;	<p><i>Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д заасан “Төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцох” тусгай шаардлагыг баримтлан ажиллаж, гол нэр төрлийн эрдсийн бүтээгдэхүүн болох нүүрс, зэсийн баяжмалын тэнцвэржүүлсэн үнэд үндэслэн нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцоолж, хуулийн шаардлагыг хангасан байна.</i></p> <ul style="list-style-type: none"> Батлагдсан ТХМ-д тусгасан тэнцвэржүүлсэн үнэд өөрчлөлт ороогүй байна. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3-т заасны дагуу 2023 оны төсвийн төсөлд нэг тонн зэсийн баяжмалын тэнцвэржүүлсэн үнийг 8,386.7 сая ам.доллар, нүүрсний үнийг 110.8 ам.доллар байхаар тооцжээ. Гол нэр төрлийн эрдсийн бүтээгдэхүүний үнэ, тухайлбал зэсийн баяжмалын үнэ 9300.0 ам.доллар/тн, нүүрсний үнэ 330.0 ам.доллар/тн байхаар төлөвлөж, 2023 оны дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг баталсан. Үүнтэй харьцуулахад гадаад нөхцөл байдал муудаж, гол нэр төрлийн эрдсийн бүтээгдэхүүний зах зээлийн эрэлт агшиж байгаа зэрэг шалтгаанаар зах зээлийн үнэ буурч, нүүрс 220.0 ам.дол/тн, зэсийн баяжмал 8,400.0 ам.дол/тн байхаар төсвийн төсөлд тооцоолжээ. <p>Хүснэгт 7. Төсвийн төсөлд тусгасан гол эрдэс бүтээгдэхүүний тэнцвэржүүлсэн үнэ, тоо хэмжээ</p> <table border="1"> <thead> <tr> <th rowspan="2">Эрдэс бүтээгдэхүүн</th> <th colspan="2">Үнэ /ам.дол/</th> <th rowspan="2">Тоо хэмжээ /сая.тн/</th> </tr> <tr> <th>Тэнцвэржүүлсэн</th> <th>Зах зээл</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Нүүрс</td> <td>110.8</td> <td>220.0</td> <td>36.5</td> </tr> <tr> <td>Зэсийн баяжмал</td> <td>8,386.7</td> <td>8,400.0</td> <td>1.4</td> </tr> </tbody> </table>	Эрдэс бүтээгдэхүүн	Үнэ /ам.дол/		Тоо хэмжээ /сая.тн/	Тэнцвэржүүлсэн	Зах зээл	Нүүрс	110.8	220.0	36.5	Зэсийн баяжмал	8,386.7	8,400.0	1.4		
Эрдэс бүтээгдэхүүн	Үнэ /ам.дол/			Тоо хэмжээ /сая.тн/														
	Тэнцвэржүүлсэн	Зах зээл																
Нүүрс	110.8	220.0	36.5															
Зэсийн баяжмал	8,386.7	8,400.0	1.4															
2	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2023 онд 3.6 хувиас, 2024 онд 2.8 хувиас, 2025 онд 2.0 хувиас тус тус хэтрүүлэхгүй байх;	<p><i>Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-т заасан нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг хуульд заасан хувиас хэтрүүлэхгүй байгаа эсэхэд шинжилгээ хийлээ.</i></p> <ul style="list-style-type: none"> Төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал 2023 онд 1,553.4 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 2.8 хувь, 2024 онд 1,604.4 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 2.8 хувь, 2025 онд 1,269.0 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 2.0 хувь байхаар тусгажээ. Батлагдсан 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал 1,906.8 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 3.6 хувиар байхаар тооцсон. Батлагдсан төсвийн хүрээний мэдэгдлийн дүн болон хуулийн хязгаараас төсвийн төсөлд тусгасан нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь хэмжээ 0.8 пунктээр доогуур байхаар тооцоолсон нь хуулийн тусгай шаардлагыг хангасан байна. <p>Хүснэгт 8. Төсвийн төсөлд тусгасан гол эрдэс бүтээгдэхүүний тэнцвэржүүлсэн үнэ, тоо хэмжээ</p> <table border="1"> <thead> <tr> <th>Үзүүлэлт</th> <th>2023</th> <th>2024</th> <th>2025</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Хуулийн хязгаар</td> <td>3.6 хувь</td> <td>2.8 хувь</td> <td>2.0 хувь</td> </tr> <tr> <td>Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь</td> <td>2.8 хувь</td> <td>2.8 хувь</td> <td>2.0 хувь</td> </tr> <tr> <td>Зөрүү</td> <td>-0.8 хувь</td> <td>-</td> <td>-</td> </tr> </tbody> </table>	Үзүүлэлт	2023	2024	2025	Хуулийн хязгаар	3.6 хувь	2.8 хувь	2.0 хувь	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь	2.8 хувь	2.8 хувь	2.0 хувь	Зөрүү	-0.8 хувь	-	-
Үзүүлэлт	2023	2024	2025															
Хуулийн хязгаар	3.6 хувь	2.8 хувь	2.0 хувь															
Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь	2.8 хувь	2.8 хувь	2.0 хувь															
Зөрүү	-0.8 хувь	-	-															

3	Тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх;	<p><i>Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3-т заасан шаардлага хангагдсан эсэхэд шинжилгээ хийлээ.</i></p> <ul style="list-style-type: none"> Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөлд нэгдсэн төсвийн нийт зарлага 2023 онд 20,475.6 тэрбум төгрөг байхаар төлөвлөж, 2022 оны батлагдсан дүнгээс 2,561.8 тэрбум төгрөг буюу 14.3 хувиар нэмэгдэхээр байна. Үндэсний статистикийн хороо, Сангийн яамны статистик мэдээнд тулгуурлан энэ хуульд заасан аргачлалыг ашиглан тооцоолоход нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлт 2023 онд 14.3 хувь байгаа нь 2011-2021 оны 12 жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлт болох 14.6 хувиас хэтрээгүй бөгөөд энэ нь хуулийн тусгай шаардлагын 6.1.2 дахь шаардлагыг хангасан. <p>Хүснэгт 9. Өмнөх 12 жилийн уул уурхайн бус бүтээгдэхүүний өсөлт /хувиар/</p> <table border="1" data-bbox="624 613 1426 770"> <thead> <tr> <th colspan="2">Шаардлага</th> <th>2023</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td><i>Тухайн оны нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь</i></td> <td>14.3</td> </tr> <tr> <td>2</td> <td><i>Тухайн оноос өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн дундаж хувь</i></td> <td>14.6</td> </tr> </tbody> </table>	Шаардлага		2023	1	<i>Тухайн оны нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь</i>	14.3	2	<i>Тухайн оноос өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн дундаж хувь</i>	14.6																
Шаардлага		2023																									
1	<i>Тухайн оны нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь</i>	14.3																									
2	<i>Тухайн оноос өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн дундаж хувь</i>	14.6																									
4	Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2023 оны төсвийн жилд 65 хувиас, 2024 оны төсвийн жилээс эхлэн 60 хувиас тус тус хэтрүүлэхгүй байна.	<p><i>Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-т өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн өрийн үлдэгдлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2023 оны төсвийн жилд 65 хувиас хэтрүүлэхгүй байх тусгай шаардлага хангагдсан эсэхийг шинжлэн үзэхэд:</i></p> <ul style="list-style-type: none"> Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдэл 2023 онд 35,434.5 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 65 хувь, 2024 онд 34,379.2 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 60 хувь, 2025 онд 38,068.7 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 60 хувьтай тэнцэхээр байгаа нь төсвийн тусгай шаардлагыг хангахаар байна. <p>Хүснэгт 10. Засгийн газрын өрийн үлдэгдэл /ӨҮЦ/</p> <table border="1" data-bbox="624 1111 1489 1458"> <thead> <tr> <th colspan="2">Үзүүлэлт</th> <th>2022 ХБГ</th> <th>2023</th> <th>Зөрүү</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td><i>Засгийн газрын нийт өрийн үлдэгдэл /тэрбум.төг/</i></td> <td>33,297.6</td> <td>39,699.3</td> <td>6,401.7</td> </tr> <tr> <td>2</td> <td><i>Өнөөгийн үнээр илэрхийлсэн Засгийн газрын нийт өрийн үлдэгдэл /тэрбум.төг/</i></td> <td>26,939,7</td> <td>35,434,5</td> <td>8,494.8</td> </tr> <tr> <td rowspan="2">3</td> <td rowspan="2"><i>Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын нийт өр / ДНБ</i></td> <td><i>Хуулийн хязгаар (хувь)</i></td> <td>70.0</td> <td>65.0</td> <td>-5.0</td> </tr> <tr> <td><i>ТХМ төсөлд (хувь)</i></td> <td>56.6</td> <td>65.0</td> <td>-</td> </tr> </tbody> </table>	Үзүүлэлт		2022 ХБГ	2023	Зөрүү	1	<i>Засгийн газрын нийт өрийн үлдэгдэл /тэрбум.төг/</i>	33,297.6	39,699.3	6,401.7	2	<i>Өнөөгийн үнээр илэрхийлсэн Засгийн газрын нийт өрийн үлдэгдэл /тэрбум.төг/</i>	26,939,7	35,434,5	8,494.8	3	<i>Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын нийт өр / ДНБ</i>	<i>Хуулийн хязгаар (хувь)</i>	70.0	65.0	-5.0	<i>ТХМ төсөлд (хувь)</i>	56.6	65.0	-
Үзүүлэлт		2022 ХБГ	2023	Зөрүү																							
1	<i>Засгийн газрын нийт өрийн үлдэгдэл /тэрбум.төг/</i>	33,297.6	39,699.3	6,401.7																							
2	<i>Өнөөгийн үнээр илэрхийлсэн Засгийн газрын нийт өрийн үлдэгдэл /тэрбум.төг/</i>	26,939,7	35,434,5	8,494.8																							
3	<i>Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын нийт өр / ДНБ</i>	<i>Хуулийн хязгаар (хувь)</i>	70.0	65.0	-5.0																						
		<i>ТХМ төсөлд (хувь)</i>	56.6	65.0	-																						

Эх сурвалж: Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Төсвийн төсөл

Гурав.Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн эсэх:

3.1.Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээнүүд нь 2023 оны улсын төсвийн төсөлд тусгагдсан байдал:

Хүснэгт 11.

Үзүүлэлт	Тусгагдсан байдал
Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний тусгасан зорилт, холбогдох шалгуур үзүүлэлт тус бүрээр төлөвлөсөн эсэх	Улсын хөгжлийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөнд Эдийн засаг, Хүний хөгжил, Засаглал, Ногоон хөгжил болон Нийслэл, бус нутаг, орон нутгийн хөгжил бүлгийн хүрээнд 18 зорилтын 75 арга хэмжээ, 204 ажил төлөвлөгдсөн. Эдгээр зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд улсын төсвөөр 1,887.7 тэрбум төгрөгийн 56 арга хэмжээ, гадаадын зээл, тусламжийн эх үүсвэрээр 1,646.5 тэрбум төгрөгийн 26 арга хэмжээ тус тус төлөвлөгдсөн.

	Улсын төсвөөр хэрэгжүүлэх 56 арга хэмжээний 91.1 хувь, гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх 26 арга хэмжээний 80.8 хувь нь улсын төсвийн төсөлд тусгагдсан байна.
--	--

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС